

Нийтийн Их Сургуулийн Тэтгэлэг, АНУ

UoPeople бол ашгийн бус, сургалтын төлбөргүй, магадлан итгэмжлэгдсэн, Америкийн анхны онлайн их сургууль юм. Дэлхий даяар дээд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд зориулагдсан UoPeople нь ахлах сургуулийн төгсөгчдөд коллежид суралцахад тулгамдаж буй санхүүгийн гачигдал, газарзүйн байрлал, улс төрийн болон хувийн бэрхшээлийг даван туулахад тусалдаг. UoPeople нь оюутнуудаас хичээл, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, жилийн элсэлтийн төлбөр авдаггүй.

UoPeople тэтгэлэг нь дэлхийн өнцөг булан бүрээс үүсэлтэй янз бүрийн эх сурвалж, хандивлагчдаас гаралтай олон төрөлт, динамик байдаг. Үүний зорилго нь ямар ч шаардлага хангасан оюутныг дээд боловсрол эзэмших эрхийг санхүүгийн шалтгаанаар болон бусад шалтгаанаар хаахгүй байх явдал юм.

I. Элсэлтийн шаардлага:

Элсэлтийн шаардлагыг хангахын тул горилогч нь:

- 16 буюу түүнээс дээш настай байх
- Ахлах сургуулиа төгссөнөө харуулах чадвартай байх
- Англи хэлний мэдлэгтэй байх

Төрөлх англи хэлгүй хүмүүс

Нэмж дурдахад, төрөлх англи хэлгүй эсвэл үндсэн хэл нь англи хэлтэй сургуульд ахлах сургуулиа төгсөөгүй өргөдөл гаргагчид өргөдөл гаргахдаа [англи хэлний мэдлэгийг нотлох](#) шаардлагатай. Өргөдөл гаргагчид англи хэлний мэдлэгээ нотлох боломжгүй бол UoPeople Бэлтгэл Сургалтад суралцахын өмнө UoPeople Англи хэлний сургалтыг амжилттай дүүргэх шаардлагатай болно.

Элсэлтийн шалгалтууд

Элсэхийн тулд элсэлтийн шалгалт өгөх шаардлагагүй - энэ нь UoPeople дахь онлайн зэрэг олгох хөтөлбөрт элсэхийн тулд стандартчилсан шалгалтын оноо өгөх шаардлагагүй гэсэн үг юм.

Бэлтгэл сургалтууд

Оюутнууд бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт хамрагдахын тулд [UoPeople Бэлтгэл Сургалт](#)-ыг амжилттай дүүргэсэн байх ёстой. UoPeople Бэлтгэл Сургалтууд нь оюутнуудад эрдмийн зэрэг дэвшихэд шаардлагатай ур чадваруудыг эзэмшүүлэх зорилготой юм. Оюутнууд UoPeople Foundations курсуудыг амжилттай давж, ахлах сургуулиа төгссөнийг нотлох баримтаа илгээсний дараа тэд UoPeople-д хүссэн бакалаврын зэрэг олгох хөтөлбөртөө үргэлжлүүлэн суралцах боломжтой. UoPeople Бэлтгэл Сургалтууд нь аспирант болон бакалаврын зэрэг олгох кредит шалгуурт тооцогдоно.

II. Суралцах чиглэл (100% онлайн бакалаврын зэрэг):

- Бизнесийн удирдлага
- Компьютерийн шинжлэх ухаан
- Эрүүл мэндийн шинжлэх ухаан

III. Бүртгэл:

- To apply for admissions consideration to UoPeople, applicants must complete an [online application](#), including payment of a \$60 non-refundable Application Fee.

- UoPeople-д элсэхийн тулд өргөдөл гаргагчид **онлайн өргөдөл** бөглөж, 60 ам. долларын буцаан олгогдохгүй Өргөдлийн хураамжийг төлөх ёстой.

IV. Ахлах сургуулиа төгссөнийг нотлох баримтыг ирүүлэх

Ахлах сургуулиа төгссөнийг нотлох баримтыг UoPeople-ийн эхний улиралд багтаан ирүүлж болно:

1. Албан ёсны диплом (эсвэл төгсөлтийг илтгэх дүнгийн хуулбар)-ыг шууд UoPeople-д илгээх (имэйлээр эсвэл цахимаар); эсвэл
2. нотариатаар гэрчлүүлсэн дипломын эх хувь (эсвэл төгсөлтийг илтгэх дүнгийн хуулбар)-ийг шууд UoPeople руу илгээх (имэйлээр эсвэл цахимаар).

***Англи хэл дээр бичигдээгүй бичиг баримтыг албан ёсны нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт ирүүлнэ. Эх хувь болон англи хувилбарыг UoPeople руу илгээх ёстой.

IV. Тэтгэлэг олгох мөнгөн дүнгийн хэмжээ: \$4,860

Дэлхийн буцалтгүй тусламжийн тэтгэлэг

АНУ-ын Ротари дистрикт 5960 клуб

Дэлхийн буцалтгүй тусламжийн тэтгэлэг (Тэтгэлэг)-ийн мөнгө нь бакалаврын түвшний хөтөлбөрүүдэд нэгээс дөрвөн жилийн хугацаанд суралцахад олгогддог.

Тэтгэлгийн мөнгийг сургалтын төлбөр, байр, хоол, ном, аяллын зардал, виз, дархлаажуулах тарилга, түүнчлэн тэтгэлэг авагчийн сургалттай холбоотой клуб эсвэл дүүргийн зүгээс төлөвлөсөн хүмүүнлэгийн төсөлд ашиглаж болно.

I. Тавигдах шаардлага

- Дэлхийн буцалтгүй тусламж нь Ротаригийн голлох зургаан чиглэлийн аль нэгтэй нь холбоотой байх, урт хугацааны үр нөлөөтэй байх ёстой бөгөөд бакалаврын түвшний хөтөлбөрт зориулагдсан байх ёстой.
- Тэтгэлэг авагчийн сургалт нь АНУ болон АНУ-ын нутаг дэвсгэрээс гадуур магадлан итгэмжлэгдсэн их сургуульд явагдах ёстой.
- Дэлхийн буцалтгүй тусламж нь тогтвортой, хэмжигдэхүйц байх ёстой (Тэтгэлэг авагчийн сургалт нь Ротаригийн зургаан чиглэлийн нэг буюу хэд хэдэн чиглэлийг хэрхэн дэмжих вэ?) Дэлхийн буцалтгүй тусламжийн хамгийн бага санхүүжилт нь 35,000 ам. доллар байна.

II. Ротаригийн голлох зургаан чиглэл:

- Энх тайван ба мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх/шийдвэрлэх
- Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх
- Ус, ариун цэврийн байгууламж
- Эх, хүүхдийн эрүүл мэнд
- Суурь боловсрол, бичиг үсэг
- Эдийн засаг, олон нийтийн хөгжил

III. Бүртгэл:

- Өмнөх жилийн өвөл эхлээд хаврын адаг үе хүртэл явагддаг.

IV. Дүүргийн өргөдөл гаргах үед шаардлагатай баримт бичиг:

- Дэлхийн буцалтгүй тусламжийн тэтгэлэгт хамрагдах өргөдөл
- Ротари анхаарлаа хандуулдаг зургаан чиглэлийн аль нэгэнд Горилж буй мэргэжил
- Горилж буй эрдмийн зэрэг, цаг хугацаа
- Тооцоолсон төсөв
- Зохион байгуулагч дүүрэгт санал болгож буй хүмүүнлэгийн ажлын төсөл (заавал биш)
- Санал болгож буй сургуульд хүлээн авах тухай захидал
- Гадаад хэлний түвшин тогтоох шалгалтын дүн
- Нарийвчилсан төсөв
- **Дараах мэдээллийг харгалзан бүрдүүлэх:**
 - Тэтгэлэг авагчийн сургалтын хөтөлбөр нь сонгосон голлох чиглэлтэй холбоотой байх.
 - Тэтгэлэг авагчийн боловсролын болон мэргэжлийн зорилго, тэтгэлэг нь эдгээр зорилгод хүрэхэд хэрхэн туслах вэ.
 - Тэтгэлэг авагч нь зохион байгуулагч болон/эсвэл олон улсын тэтгэлгийн нийгэмлэгийн хэрэгцээг урт хугацаанд хангахын тулд боловсролоо хэрхэн ашиглах вэ?

IV. Сонгон шалгаруулалт

Өргөдлийг онлайнаар гаргах боломжтой (<https://rotary5960.org/page/global-grant-fellowship> вэб хуудасны зүүн гар талын цэс дэх "Өргөдөл гаргах баримт бичиг"-ийг үзнэ үү).

Өргөдлийг тухайн оны 4-р сарын 22-ны дотор тус Орон нутгийн клубд хүлээн авах ба ярилцлага мөн оны 5-р сарын 04-ний өдрийн 10:00-16:00 цагийн хооронд Байршил тухайн үед зарлагдах (өргөдөл гаргагч нь ярилцлагад орох боломжтой байх) бөгөөд удаах жилийн намар эхлэх сургалтын өргөдлийн боловсруулалт олон улсын хэмжээнд тухайн жилийн өвөл/хавар явагдана.

Тэтгэлэг авагчийн анхаарах зүйл:

- 1. Ротаригийн гишүүн;**
- 2. клуб, дүүрэг, эсвэл бусад Ротари байгууллага эсвэл Олон улсын Ротари байгууллагын ажилтан;**
- 3. Өмнөх хоёр ангилалд хамаарах аливаа хүний эхнэр, нөхөр, удам угсаа (хууль ёсоор үрчилж авсан хүүхэд, дагавар хүүхэд, үрчлээгүй хүүхэд), удам угсааны эхнэр, нөхөр, эсвэл өвөг дээдэс (төрсөн эцэг эх эсвэл өвөө, эмээ) биш байх ёстой.**

ЖИЧ:

- Дэлхийн буцалтгүй тусламжийн тэтгэлэгт хамрагдах өргөдлийг бөглөж, сканердсаны дараа Кайл Хаугенд jkylehaugen@gmail.com хаягаар илгээнэ. Өргөдөл болон эсээний баримт бичгийг хавсаргасан байх ёстой.
- Adobe Acrobat форматаар 2020-21 оны дэлхийн буцалтгүй тусламжийн тэтгэлэгт хамрагдах өргөдлийн маягтын хуулбарыг [ЭНД](#) дарж үзнэ үү.